

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 24 оны 06 сарын 04-ны өдөр

№ 15

Улаанбаатар хот

Аудитын байгууллага сонгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудит, эрдэлийн удирдлагын хорооны 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Компани нь “Хүлэгт хүннү аудит” ХХК-ийг компанийн 2024 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргах байгууллагаар сонгосугай.
2. Энэхүү тогтоолын дагуу “Хүлэгт хүннү аудит” ХХК-тай холбогдох гэрээ байгуулах, гарын үсэг зурах, гэрээний үнийг тогтоох бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ




ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 *24* оны *06* сарын *04*-ны өдөр

№ *16*

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (Цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.20 дахь заалт, Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсгийг тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компани нь “Хайпэй” ХХК-тай нэг сарын 7,435,000 (*долоон сая дөрвөн зуун гучин таван мянган*) төгрөгийн “Үйлчилгээ үзүүлэх гэрээ” буюу сонирхлын зөрчилтэй хэлцлийг 2 жилийн хугацаатайгаар байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-д дурдсан эрх хэмжээний хүрээнд сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ

